



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/219

Ховд

Жуух бичгээр шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “А” дахь заалт, аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн “Е”, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. КОВИД-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, хариу арга хэмжээ авах чиглэлээр ард иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, эмнэлгийн үйлчилгээг хурдан шуурхай, чанартай хүргэх үйлсэд өөрийн хүч хөдөлмөр, сэтгэл оюунаа дайчлан ажилласан Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, халдвар судалч Б.Одхүү, БЗДХ, сүрьеэ, өсвөр үеийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн Г.Саруул-Од, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн Эрчимт эмчилгээний тасгийн сувилагч Г.Гантулга, төвлөрсөн ариутгалын тасгийн сувилагч Б.Оюунтуул, лабораторийн тасгийн лаборант О.Дархижав, лаборант Т.Өлзийбаяр нарыг аймгийн Засаг даргын “Жуух бичиг” –ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын Жуух бичгээр шагнагдсан Б.Одхүү, Г.Саруул-Од, Г.Гантулга, Б.Оюунтуул, О.Дархижав, Т.Өлзийбаяр нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал /П.Гэрэлсүрэн/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

D/Zah-A/219-Bo
02 2150